# ОЧИР УНДРАА ХХК-ИЙН “ХИМИЙН БОДИС ПИРОТЕХНИКИЙН” АГУУЛАХЫН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

**Улаанбаатар хот**
**2025 он**

## АГУУЛГА


ОРШИЛ ........ 1

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 2

1.1. Төслийн нэр ........ 2

1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага ........ 2

1.3. Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг ........ 2

1.4. Төслийн зорилго ........ 3

**1.5. Төслийн үйл ажиллагаа** ........ 3

**1.6. Химийн бодис тээвэрлэлт** ........ 5

**1.7. Төслийн талбайн үндсэн байгууламжууд** ........ 6

**1.7.1. Аммонийн нитратын агуулах** ........ 7

**1.7.2. Пиротехникийн хэрэгслийн агуулах** ........ 8

**1.7.3. Химийн бодисын агуулах** ........ 9

**1.7.4. Харуул хамгаалалт** ........ 9

**1.7.5. Аянга зайлуулагч** ........ 9

**1.8. Хог хаягдлын менежмент** ........ 10

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ........ 11

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ........ 12

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 13

4.1 Гол зорилт ........ 13

4.2 Хамрах хүрээ ........ 13

5. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ ........ 14

## ХҮСНЭГТ

*Хүснэгт 1. Төслийн булангийн цэгийн координат* ....... 2
*Хүснэгт 2. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд* ....... 3
*Хүснэгт 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт* ....... 12

## ЗУРАГ

*Зураг 1. Агуулахын байршил* ....... 2
*Зураг 2. Агуулахад химийн бодисыг байршуулах схем зураг* ....... 5
*Зураг 3. Пиротехникийн хэрэгслийн хураалт* ....... 5
*Зураг 4.. Агуулахын хашаа болон үерийн уснаас хамгаалах сувгийн зураг* ....... 6
*Зураг 5.Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын палан зураг* ....... 6
*Зураг 6. Химийн бодисын агуулах* ....... 7
*Зураг 7. Анхны тусламжийн өрөө* ....... 7
*Зураг 8. Хувцас солих болон зааварчилгаа өгөх өрөө* ....... 7
*Зураг 9. Аммонийн нитратын агуулахын схем зураг* ....... 8
*Зураг 10. Пиротехникийн хэрэгслийн агуулахын схем зураг* ....... 8
*Зураг 11.Химийн бодисын агуулахын схем зураг* ....... 9
*Зураг 12.Төслийн талбайн барилга байгууламж болон аянга зайлуулагчид* ....... 9
*Зураг 13. Гал унтраах багаж хэрэгсэл* ....... 10

# ОРШИЛ

Очир Ундраа ХХК нь 2000 онд анх уул уурхайн тоног төхөөрөмжийн импорт, худалдааны чиглэлээр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан. 2002 оноос эхлэн БНХАУ-аас пиротехникийн хэрэгсэл, төрөл бүрийн салют импортлон худалдаалах ажлыг эрхлэн явуулж байгаа бөгөөд эдүгээ агуулахдаа өргөтгөл хийж олон улсын жишигт нийцсэн химийн бодисуудыг оруулж ирэн нэр төрөл, тоо хэмжээг өргөжүүлэх үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Очир Ундраа ХХК-ийн "Химийн бодис, пиротехникийн агуулах" төслийн үйл ажиллагаанд БОАЖЯ-ны 2023.06.08 ны өдрийн 12/3202 тоот ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасны дагуу энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Баялаг эко ХХК боловсруулсан.

Төслийн БОННҮ-ний төлөвлөгөөг БОНХ-ийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн А117 тоот тушаалын 2-р хавсралтаар батлагдсан "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал", БОМТ-ын төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам дагуу боловсруулав. Химийн эрсдэлийн үнэлгээг А-50/378/656 тоот тушаалын 2 дугаар хавсралт "Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

"Химийн бодис, пиротехникийн агуулах" төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн хүрээнд төслийн үйл ажиллагаанаас үүсэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээ, болзошгүй эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ зэргийг төлөвлөн, цаашид Очир Ундраа ХХК-ийн байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан, холбогдох зардлуудыг тусгав.

# 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Төслийн нэр

Химийн бодис пиротехникийн агуулах төсөл

## 1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага

- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Очир Ундраа ХХК
- Улсын бүртгэлийн дугаар: 9011122089
- Регистрийн дугаар: 2659603
- Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 8/1, Сити Тауэр бизнес төв, 17 давхарт
- Утас: +976-75757979, +976-11- 326466

## 1.3. Төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг

Очир Ундраа ХХК-ийн Химийн бодис пиротехникийн агуулах нь Налайх дүүргээс 5 км зайд, Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. 2.119 га үйлдвэрийн зориулалттай газар үйл ажиллагаагаа явуулдаг. Төслийн талбайн булангийн цэгүүдийг Хүснэгт 1-т, байршлын зургийг **Error! Reference source not found.**т харуулав.

*Зураг 1. Агуулахын байршил*




*Хүснэгт 1. Төслийн булангийн цэгийн координат*

| № | X | Y | H |
|---|---|---|---|
| 1 | 668474.610 | 5290420.460 | 1526.150 |
| 2 | 668461.612 | 5290420.080 | 1526.070 |
| 3 | 668426.646 | 5290454.558 | 1528.310 |
| 4 | 668687.595 | 5290461.110 | 1534.470 |
| 5 | 668691.400 | 5290353.070 | 1528.740 |
| 6 | 668551.070 | 5290349.540 | 1528.650 |

## 1.4. Төслийн зорилго

Очир Ундраа ХХК нь Олон улсын жишигт нийцсэн химийн бодисуудыг МЕРА ХХК, Бүтээгч ХХК, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Бор Өндрийн уулын баяжуулах үйлдвэр, Шивээ Овоо ХК, Багануур ХК, Оюу Толгой ХХК зэрэг Монгол улсын томоохон уурхай, компаниудад нийлүүлэн, химийн бодис, түүхий эдээр хангах, Шинэ жил, Улсын баяр наадам зэрэг томоохон шоу цэнгүүнд пиротехникийн үйлчилгээ үзүүлэх, хадгалах зорилготой үйл ажиллагаагаа явуулдаг байна.

## 1.5. Төслийн үйл ажиллагаа

Агуулахад хадгалдаг химийн бодисуудыг ОХУ-ийн “Кемерово Азот”, “Ангарскийн Азот үйлдвэр” /СДС Азот/, “Мелеузын бордооны үйлдвэр”, “Аммоний үйлдвэр”Хятад улсын Shandong Guanghe Trading Co.Ltd., Shijia Zhuang Xinlongwet Chemical Co.,Ltd, Shijiazhuang Xinlonggwei Chemical Co.,Ltd компаниудтай гэрээ байгуулан импортлон оруулж ирдэг ба бодисын төрөл тоо хэмжээгээ нэмэгдүүлэн 46 төрлийн бодисуудыг хадгалахаар төлөвлөөд байна.

***Хүснэгт 2. Химийн бодисын агуулахад хадгалагдах химийн бодисууд***

| № | Олон улсын нэршил | Монгол нэр | Химийн томьёо | CAS дугаар | Хэмжээ, 5 жилд /тн/ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аммонийн нитрат | Ammonium nitrate | $NH_4NO_3$ | 6484-52-2 | 10 000 |
| 2 | Аммонийн нитрат,сүвэрхэг | Ammonium nitrate, porous | $NH_4NO_3$ | 6484-52-2 | 20 000 |
| 3 | Натрийн нитрит | Sodium nitrite | $NaNO_2$ | 7632-00-0 | 40 |
| 4 | Эмульгатор | Emulgator | | | 140 |
| 5 | Хөнгөн цагааны нунтаг | Aluminum powder | Al | 7429-90-5 | 40 |
| 6 | Мочевин | Urea | $CN_4N_2O$ | 57-13-6 | 200 |
| 7 | Теомочевин | Thiourea | $CN_4N_2S$ | 62-56-6 | 120 |
| 8 | Натрийн нитрат | Sodium nitrate | $NaNO_3$ | 7631-99-4 | 300 |
| 9 | Цууны хүчил | Acetic acid | $CH_3COOH$ | 64-19-7 | 60 |
| 10 | Этиленгликоль | Ethylene glycol | $C_2H_6O_2$ | 107-21-1 | 240 |
| 11 | Давсны хүчил | Hydrochloric acid | HCL | 7647-01-0 | 500 |
| 12 | Парафин | Paraphine | | | 500 |
| 13 | Натрийн гипохлорит | Sodium hypochlorite | NaClO | 7681-52-9 | 220 |
| 14 | Хүхэрт натри | Sodium sulphide | $Na_2S$ | 1313-82-2 | 3 000 |
| 15 | Шингэн шил | Sodium metasilicate | $Na_2SIO_3$ | 6834-92-0 | 240 |
| 16 | Хүхрийн хүчил | Sulphuric acid | $H_2SO_4$ | 7664-93-9 | 200 |
| 17 | Нийлмэл бордоо | Complex fertilizer-NPK | | | 5 000 |
| 18 | Аммофоска | Amofoska | | 8011-76-5 | 5 000 |
| 19 | Поликарбоксилат | Polycarboxylate superplasticizer | | 9084-06-4 | 1 000 |
| 20 | Хөргөлтийн шингэн | Antifreeze | | | 3 000 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 21 | Тос тосолгооны материал | lubricating oil | | | 15 000 |
| 22 | Шүвтрийн шүү | Ammonium Nitrate | $NH_4NO_3$ | 6484-52-2 | 10 000 |
| 23 | Нийлмэл бордоо | Complex fertilizer-NPK | $N; P_2O_5 ; K_2O$ | Нийлмэл бодис | 6 000 |
| 24 | Фосфорын бордоо | Superphospate | $Ca(H_2PO_4)_2$ | 1314-56-3 | 7 000 |
| 25 | Шүвтэр | Urea | $CO(NH_2)_2$ | 57-16-6 | 8 000 |
| 26 | Аммонийн фосфат | Diammonium Phosphate /DAP/ | $(NH_4)_2PO_4$ | 7783-28-0 | 3 000 |
| 27 | Моно аммонийн фосфат | Monoammonium Phosphate | $NH_4H_2PO_4$ | 0007722-76-1 | 4 000 |
| 28 | Азот, фосфорын нийлмэл бордоо | Complex fertilizer-NP | $N; P_2O_5$ | Нийлмэл бодис | 1 000 |
| 29 | Диаммофоска | Diammonium Phosphate /DAP/ | $N; K_2O; P_2O_5$ | 7783-28-0 | 2 000 |
| 30 | Калийн бордоо | Potassium chloride | KCl | 7447-40-7 | 3 000 |
| 31 | Алмазис, ВГД | Metsulfuron-methyl | $C_{14}H_{15}N_5O_6S$ | 74223-64-6 | 1 000 |
| 32 | Глифосат | Glyphosate | $C_3H_8NO_5P$ | 1071-83-6 | 1 000 |
| 33 | Фаскорд КЭ | α-Cypermethrin | $C_{22}H_{19}\,CL_2NO_3$ | 67375-30-8 | 1 000 |
| 34 | Каратэ, МКС | Cyhalothrin | $C_{23}H_{19}\,CL\,F_3\,NO_3$ | 91465-08-6 | 1 000 |
| 35 | Табу, ВСК | Imidacloprid | $C_9H_{10}\,CLN_5O_2$ | 138261-41-3 | 1 000 |
| 36 | Тебу 60, МЭ | Tebuconazole | $C_{16}H_{22}\,CLN_3\,O$ | 107534-96-3 | 1 000 |
| 37 | Метамил МЦ | Metalaxyl | $C_{15}H_{21}\,NO_4$ | 57837-19-1 | 1 000 |
| 38 | Пумасупер | Fenoxaprop-P-ethyl | $C_{18}H_{16}ClNO_5$ | 71283-80-2 | 10 000 |
| 39 | Фротер | Frother; oreprep | | Нийлмэл бодис | 10 000 |
| 40 | Аэрофин | Aerophine 3422 | | Нийлмэл бодис | 10 000 |
| 41 | Аэрофин | Aerophine 3418A | | Нийлмэл бодис | 10 000 |
| 42 | Флокулент | Flocculent;SNF;an934 | | Нийлмэл бодис | 10 000 |
| 43 | Ингибитор | Inhibitor;corrosion mild steel | | Нийлмэл бодис | 10 000 |
| 44 | Антисклант | Antiscalant; govigurv; GX#ASI-311 | | Нийлмэл бодис | 10 000 |
| 45 | Ингибитор | Inhibitor;corrosion yellow metal | | Нийлмэл бодис | 10 000 |
| 46 | Титанийн нийлмэл нунтаг | Composite titanium powder | | 7440-32-6 | 1 000 |

Химийн бодисын агуулахад бодис бүрийн шинж чанарыг харгалзан өөр, өөр өрөөнд доорх зурагт үзүүлсний дагуу эгнүүлэн хадгалах юм.

*Зураг 2. Агуулахад химийн бодисыг байршуулах схем зураг*




Таних тэмдэг

- Подон 120х100см
- Аммонийн нитрат /Биг баг 90х90х150см/
- Аммонийн нитрат /40 кг 50х20х25см/

Тайлбар

-Подон Бигбаг-н агуулахад 83 ширхэг, шуудаайтай агуулахад 76 ширхэг

-Бигбаг нэг агуулахад 97 ширхэг /82,450 кг*2=164,900 кг/

-Шуудай /40 кг/ нэг агуулахад 4912 ширхэг /196,480 кг, 8 давхарлаж өрнө/

- Нийт 242 ширхэг подон

- 361,380 кг аммонийн нитрат

*Зураг 3. Пиротехникийн хэрэгслийн хураалт*



## 1.6. Химийн бодис тээвэрлэлт

Очир Ундраа ХХК нь химийн бодис пиротехникийн хэрэгслийг Эрээн-Замын-Үүд, Хиагт-Алтанбулагийн авто зам, Сүхбаатар-Наушкийн төмөр замын боомтуудаар химийн бодисуудаа импортолдог. Гаалийн бүрдүүлэлт хийсний дараа ачаа тээврийн Огоот ХХК-аар тээвэрлүүлэн агуулахад хүргүүлдэг байна. Огоот ХХК- тай №Г-21-003 дугаартай “Ачаа тээвэрлэлт үйлчилгээ үзүүлэх болон хамтын ажиллагаа”-ны гэрээ” байгуулан хамтран ажилладаг. Тус компани нь “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн үед мөрдөх аюулгүй ажиллагааны журам”–аар зөвшөөрөл авсан тээврийн хэрэгслээр аммиакийн шүү, химийн бодис, пиротехникийн хэрэгслүүдээ тээвэрлэн хүргэдэг.  Гэрээ, тээврийн хэрэгслүүдийн зөвшөөрлийг хавсралтаар оруулав.

## 1.7. Төслийн талбайн үндсэн байгууламжууд

Төслийн хашаа нь хойд талаараа МЕРА ХХК-ийн хашаатай залгаа, баруун, зүүн, урд талаараа 2 метрийн өндөртэй торон хашаа барьж байгуулсан. Торон хашааны гадуур 50 метрийн радиуст “Хориотой бүс” анхааруулах тэмдэг тавьсан. Эргэн тойрны дэвсгэр газарт хашаанаасаа 5 метрийн зайд 0.5 метрээс багагүй гүнтэй үер ус ба гал түймрээс хамгаалах шуудуу татсан байна. Зүүн урд талаасаа орох хаалгатай ба хаалганаас зүүн урагш 200 м газарт “Цугларах цэг” байршуулсан байна.

***Зураг 4.. Агуулахын хашаа болон үерийн уснаас хамгаалах сувгийн зураг***



*Зураг 5.Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын палан зураг*

Хавсралт №3

## Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахуудын палан зураг




**Тайлбар**

1. Харуулын байр
2. Аммонийн нитратын агуулах /төмөр чингэлэг/
3. Аммонийн нитратын агуулах /сэндвич/
4. Хамгаалалтын далан
5. Аянга зайлуулагч
6. Хамгаалалтын торон хашаа
7. Ус зайлуулах шуудуу
8. Дайрга асгах талбай
9. Агуулахын гэрэлтүүлэг
10. Галын эсэргүүцэх байгууламж
11. Газардуулагч
12. Тэсрэх материалын агуулах /төмөр чингэлэг/
13. Бандан кран байрлах талбай
14. Агуулахын үүдэн хэсгийн цементэн талбай

| | | | Гарын үсэг | Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын төсөл | ОЧИРУНДРАА |
|---|---|---|---|---|---|
| Танилцсан | Гүйцэтгэх захирал | Г.Мөнхзул | | | |
| Хянасан | Инженер | Б.Болдбаатар | | Химийн бодис, Пиротехникийн хэрэгслийн агуулахын палан зураг | "Очир Ундраа" ХХК |
| Зурсан | Мастер | Л.Басдорж | | | Оноо |
| | | | | | Масштаб 1:1000 |

Химийн бодис пиротехникийн агуулах төсөл нь барилга байгууламжийн хувьд аммонийн нитратын агуулах, пиротехникийн хэрэгслийн агуулах, химийн бодисын агуулах гэсэн 3 үндсэн агуулахын барилгаас бүрдэнэ. Дотроо анхны тусламжийн өрөө, зааварчилгаа өгөх, хувцас солих өрөөг тохижуулсан байна.

***Зураг 6. Химийн бодисын агуулах***



*Зураг 7. Анхны тусламжийн өрөө*



***Зураг 8. Хувцас солих болон зааварчилгаа өгөх өрөө***



## 1.7.1. Аммонийн нитратын агуулах

Аммонийн нитратын агуулах нь 50.4 м урт, 15 м өргөн, 4 м өндөр, 750 м.кв талбайтай, 400 тн багтаамжтай төмөр карказан сэндвичин барилга. 17х15 хэмжээтэй, автомашины дөрвөн том хаалгатай, нэг явган хаалгатай, 17х15 хэмжээтэй, автомашины дөрвөн том хаалгатай, 12х15 хэмжээтэй, автомашины гурван том хаалга, нэг явган хаалгатайгаар нийт гурван тасалгаатай баригдсан.

*Зураг 9. Аммонийн нитратын агуулахын схем зураг*

**Аммонийн нитратын агуулахын схем зураг**




## 1.7.2. Пиротехникийн хэрэгслийн агуулах

Пиротехникийн хэрэгслийн агуулах нь 40 тн багтаамжтай 5 ширхэг газрын дээрх чингэлэг агуулах байрлуулсан.

*Зураг 10. Пиротехникийн хэрэгслийн агуулахын схем зураг*



### 1.7.3. Химийн бодисын агуулах

Химийн бодис хадгалах 40 тн багтаамжтай 3 ширхэг газрын дээрх чингэлэг агуулахуудыг зэрэгцүүлэн байрлуулсан байна.

*Зураг 11.Химийн бодисын агуулахын схем зураг*




### 1.7.4. Харуул хамгаалалт

Агуулахыг нийтэд нь хянах боломжтой шалган нэвтрүүлэх байр нь хашааны зүүн урд байрлах бөгөөд хамгаалалтын тусгай хэрэгсэл болон холбоогоор бүрэн хангагдсан гэрээт харуул хамгаалалтын албыг 24 цагаар ажиллуулдаг.

### 1.7.5. Аянга зайлуулагч

Нийт 4 аянга зайлуулагчтай. Химийн бодисын агуулахын зүүн тал 1 ширхэг, Аммонийн нитратын агуулахын хоёр талд 2 ширхэг, пиротехникийн хэрэгслийн агуулахын баруун талд 1 ширхэг аянга зайлуулагч байрлуулсан.

*Зураг 12.Төслийн талбайн барилга байгууламж болон аянга зайлуулагчид*



**Гал эсэргүүцэх цэг:** Нийт 4 галын сарайтай. Химийн бодисын агуулахын зүүн тал 1 ширхэг, Аммонийн нитратын агуулахын хоёр талд 2 ширхэг, пиротехникийн хэрэгслийн агуулахын зүүн урд талд 1 ширхэг галын сарай байрлуулсан.

***Зураг 13. Гал унтгаах багаж хэрэгсэл***



## 1.8. Хог хаягдлын менежмент

Төслийн талбайд ажилчид байрлахгүй бөгөөд харуул хамгаалалтын ажилчид болон химийн бодис ачиж зөөх ажилчид тухай бүрд ирж ажиллах бөгөөд ахуйн гаралтай хог хаягдал маш бага хэмжээтэй гарахаар байна. Үүнийг зэргэлдээ орших МЕРА ХХК-ийн ахуйн хог хаягдалтай нийлүүлэн хаядаг байна. Харин зарим тохиолдолд химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдал гарч болзошгүй учир энэ төрлийн хог хаягдлыг Төв аймгийн Сэргэлэн сумын I багийн нутаг, IV зөрлөгийн орчимд химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодол дахин боловсруулдаг “Түмэн эгшиг” ХХК-тай химийн бодисын хаягдал, баглаа боодол шилжүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

# 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## I. БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

***Физик газар зүй:*** Очир Ундраа ХХК-ийн хэрэгжүүлж буй "Химийн бодис пиротехникийн агуулах төсөл нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хороонд байрлана. Төсөл хэрэгжих бүс болох Улаанбаатар хот  нь Монгол орны физик газар зүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтраг үзүүрт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг.

***Уур амьсгал:*** Улаанбаатар хот нь эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөл нь уулсын байрлал, тэдгээрийн хажуугийн зүг зовхисын байдал, хотгор гүдгэрийн ерөнхий төрхтэй уялдан хөрс, ургамлан нөмрөг, гадаргын ус, улирлын хөлдөлт гэсэлт, бичил уур амьсгал бүрэлдэн тогтох онцлог нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь ялангуяа уулсын ам хөндий, ах өвөр хажууд тодорхой ажиглагддаг. Уулсын ам хөндийнүүдээр урсах гол горхины ус нь ихэнх тохиолдолд адаг орчимдоо сэвсгэр хурдас доогуур шурган ордог боловч хур бороо элбэг үед түр зуур ил урсан Туул голд цутгадаг. Туул гол, түүний цутгал гол горхины үндсэн тэжээл нь зун, намрын хур борооны ус юм. Ийнхүү эх газрын эрс тэс уур амьсгалын нөлөөгөөр хур тунадас бага, жил хоногийн температурын ялгаа их бүс нутаг юм.

***Хөрсөн бүрхэвч:*** Төсөл хэрэгжих Налайх дүүргийн нутаг нь байгалийн бүсийн хувьд ойт хээр бүсэд хамрагдана. Энэ дэд бүс нутагт Хар хүрэн хэв шинжийн хөрс зонхилон тархдаг байна. Мөн Хар шороон болон Аллювын хэв шинжийн хөрснүүд дагалдах байдлаар багахан талбайд тархдаг.

***Амьтны аймаг:*** Амьтан, ургамлын аймгийн экосистемийн шинж төрх бүрэн алдагдаж, амьтны зүйлийн бүрдэл нь хот суурин, хүний ойр орчимд амьдардаг синантроп зүйлүүд суурьших болжээ. Улаанбаатар хотод амьтны аймгаас хамгийн өргөн тархсан цөөн зүйлийн шувуу, шавж, хөхтөн судалгаагаар тодорхойлогдсон байдаг. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн ба хээрийн бор шувуу, шаазгай, сохор элээ, хөх бор тагтаа, хар элээ, хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, гэрийн хулгана, үлийн цагаан оготнууд байна.

# 3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

*Байгаль орчин:* Нийслэлийн Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж байгаа Очир Ундраа ХХК-ийн Химийн бодис пиротехникийн агуулах төслийн үйл ажиллагаа болох химийн бодис хадгалалт, тээвэрлэлт, ачиж буулгах үйл ажиллагаанаас агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг зэрэг байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдэд шууд болон дам нөлөө үзүүлж болзошгүй байна.

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүр дээр тооцсон ба нийт 11 сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнээс 1 буюу 9 % нь бага, 5 буюу 45.5 % нь дунд, 5 буюу 45.5% нь их гэсэн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь дундаас их зэрэглэлд хамаарч байна.

***Хүснэгт 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлт***

| Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг | Нөлөөллийн үнэлгээ | | | Нийт |
|---|---|---|---|---|
| | **Бага** | **Дунд** | **Их** | |
| Агаарын чанар | | 1 | 2 | 3 |
| Газрын доорх ус | | | 1 | 1 |
| Ургамлан нөмрөг | | 3 | | 3 |
| Хөрсөн бүрхэвч | 1 | 1 | 2 | 4 |
| **Нийт (тоогоор)** | **1** | **5** | **5** | **11** |
| **Нийт (хувиар)** | **9%** | **45.5%** | **45.5%** | **100%** |

*Хүний эрүүл мэнд:* Химийн бодисын хадгалалт тээвэрлэлт, ачиж буулгах үйл ажиллагаанаас үүдэн тухайн үед ажиллах ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй. Ажилчдын эрүүл мэндэд учруулах нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмж, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд даган мөрдөж, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг бүрэн өмсөж хэвшсэнээр эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах, арилгах бүрэн боломжтой байна.

# 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

## 4.1 Гол зорилт

Очир Ундраа ХХК-ийн Химийн бодис пиротехникийн агуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

## 4.2 Хамрах хүрээ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд Очир Ундраа ХХК-ийн Химийн бодис пиротехникийн агуулах төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй. Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 1-ний дотор Налайх дүүргийн ЗДТГ-т танилцуулан, 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг БОАЖЯ-аар батлуулах үүрэгтэй.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг эхний таван жилээр тооцсон болно.

## 5. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ТАЙЛАН, ЗАРЦУУЛАЛТ

| Зардлын хэлбэр | Хугацаа | Үнийн дүн |
|---|---|---|
| **СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН** | | |
| **Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний тайлан** | | |
| Агаарт ялгарах бохирдуулагч үнэрийг хүлцэх хэмжээнд байлгахын тулд агуулахын дотоод орчны агааржуулалтын системийг сайжруулан, агааржуулагчийг тухай бүр шалган тогтмол ажиллуулж байна. | 5,6,9 сард | 450,000 |
| Агуулахын дотоод болон гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээг тогтмол явуулан цэвэрлэгээ хийж орчнийг цэвэрлэв. | тогтмол | |
| **Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний тайлан** | | |
| Түүхий эдийн агуулах тохижуулах, ил задгай талбайд хог ургамал байршуулахгүй байх | | |
| **ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН** | | |
| “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Налайх дүүрэг болон 3-р хорооны удирдлагуудтай хамтран гэрээ байгуулан Монгол хөрс 4 улиралын хүлэмж ХХК-д 400,000 төгрөгийн мод бут худалдан авч өгсөн. | 10 сард | 400,000 |
| Агуулахын дотоод орчныг тохижуулан сайжруулсан, дүүргийн заасан газар модны суулгац суулгав. | 5 сард | |
| **ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН** | | |
| Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавин 24 цагийн харуул хамгаалалт, камераар хяналт хийж байна. | Жилийн турш | |
| Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах тухай сургалт бүх ажилчдад орсон. | 5 сард | 1,000,000 |

| | | |
|---|---|---|
| Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх хадгалахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулахаас гадна болзошгүй аюул, осол гарсан үед хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд үүсэх хохирлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дарааллыг тогтоосон “Аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө” боловсруулж, тухайн орон нутгийн Онцгой байдлын газраар батлуулсан хэрэгжүүлэх. | 1 сард | |
| Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг, шаардлагатай тохиолдолд нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлэх, таниулахаар самбар байрлуулав. | 4 сард | |
| Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх хадгалахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангаж, тэмдэг тэмдэглэгээ, хаяг байршлыг шинэчлэн сайжруулсан. | 8 сард | 4,032,000 |
| **ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН** | | |
| Ахуйн хатуу хог хаягдлын түр цэг байгуулах. Энэ нь хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой байх, хаягжуулсан байх | 6 сард | |
| Налайх дүүргийн ТҮК-тай “Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх | 9 сард | 660,000 |
| Химийн бодисын сав баглаа боодлыг аюулгүй зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах | 9 сард | 5,000,000 |
| Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах, түр хадгалах байрыг барьж байгуулах | 3 сард | |
| **БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН** | | |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх | 6 сард | 1,500,000 |
| Химийн бодис, пиротехникийн хэрэгслийн агуулахыг стандартын дагуу тохижуулах | Жилд | |
| Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаат эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх | Жилд | |
| Ажлын байранд эмийн сан бий болгох | 6 сард | 2,500,000 |
| Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах | 2 сард | |
| Галаас хамгаалах хэрэгслээр тоноглох | 3сард | |

| | | |
|---|---|---|
| **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН** | | |
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах | 10 сард | |
| **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАН** | | |
| Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэн агаар, хөрсний дээж авхуулан шинжилгээ хийлгүүлэв. | 9 сард | 94,500 |

- **2025 онд байгаль орчны менежметийн зардалд 6,000,000 төгрөг зарцуулахаар төлөвлөж байсан болович 15,636,500 төгрөг зарцуулсан байна. Ажлын тайланг хавсралтаар зураг болон төлбөр төлсөн баримтаар баталгаажуулан хавсаргав.**

# СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

АГААРЖУУЛАЛТЫН ХООЛОЙД 2 УДАА ҮЗЛЭГ ХИЙЖ ЗАСАЖ САЙЖРУУЛАВ.






ГАДАА ОРЧНИЙГ ЦЭВЭРЛЭН ЗАСАЖ ШИНЭЧЛЭВ.





ХОГИЙН САВАА ЦЭВЭРЛЭН БУДАЖ ЗАСАВ.



ЧИЙГШИЛ ХЭМЖИГЧ, АНХНЫ ТУСЛАМЖИЙН САВ БАЙРЛУУЛСАН







АВТО МАШИНЫ ЗОГСООЛ БЕТОНДОВ.



АГУУЛАХЫН ДОТООД ОРЧИНГ ЗАСАН САЙЖРУУЛАВ.




НАЛАЙХ ДҮҮРЭГТЭЙ ХАМТРАН МОД БУТ СУУЛГАВ.



# ОРЧНЫ ТОХИЖИЛТ,
# ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

НАЛАЙХ ДҮҮРЭГТЭЙ ХАМТРАН МОД БУТ СУУЛГАВ.



# Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: **S60181618202509233**

Татсан огноо: **2025-09-25 09:41**

| Шилжүүлэгчийн дансны дугаар | Хүлээн авагчийн данс | Гүйлгээний дүн | Гүйлгээний төлөв |
|---|---|---|---|
| **1905003694**<br>**MN300015001905003694** | **MN080005005779454929** | **400,000.00 MNT** | **Амжилттай** |

| | | |
|---|---|---|
| Шилжүүлэгчийн нэр<br>**ОЧИР-УНДРАА ХХК** | Хүлээн авагчийн нэр<br>**МОНГОЛ ХӨРС ДӨРВӨН УЛИРЛЫН ХҮЛЭМЖ** | Гүйлгээний утга<br>**2659603 МОД,МОНГОЛ ХӨРС ДӨРВӨН УЛИРЛЫН Х** |
| | Хүлээн авагчийн банк<br>**ХААН ТӨВ БАНК** | Гүйлгээний огноо<br>**2025-09-23** |

ГОЛОМТ БАНК 01 ХУУЛБАР ҮНЭН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

# ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН

БАТЛАВ.
"ОЧИР УНДРАА" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.МӨНХЗУЛ

БАТЛАВ.
"ШИНЭ ХАРЦАГА" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.БАЯРСАЙХАН

# ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ГЭРЭЭ

2024 оны 12 сарын 15-ны өдөр №ХГ-24/12/11 Улаанбаатар хот

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү хамгаалалтын гэрээг нэг талаас "ОЧИР УНДРАА" ХХК-ийг төлөөлж, гүйцэтгэх захирал Г.МӨНХЗУЛ (цаашид Үйлчлүүлэгч тал гэх), нөгөө талаас Хууль зүй, Дотоод хэргийн яамны гэрээт харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрлийн №202407000054 тоот бүртгэлийн дугаар бүхий харуул хамгаалалтын "ШИНЭ ХАРЦАГА" ХХК-ийг төлөөлж, гүйцэтгэх захирал М.Баярсайхан (цаашид Хамгаалагч тал гэх) нар нь Налайх дүүргийн 3-р хороонд байрлах байрлах "Пиротехник, химийн бодисын агуулахыг хамгаалуулахаар харилцан тохиролцож байгуулав.

1.2. Харуул хамгаалалтын энэхүү гэрээний харилцаа нь Монгол улсын Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль, Монгол улсын Иргэний хууль болон бусад хуулиар зохицуулагдана.

1.3. Харуул хамгаалалтын үргэлжлэх хугацаа, горим, ээлжийг харуул хамгаалалт тасралтгүй ажиллах шаардлагад нийцүүлэн Монгол улсын Хөдөлмөрийн хуулийн дагуу харуул хамгаалалтын алба зохион байгуулж ажиллана.

## Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт, нэмэлт, тодотгол оруулж болох бөгөөд оруулах өөрчлөлт, нэмэлтийн талаар 2 тал харилцан тохиролцож шийдвэрлэн бичгээр үйлдэнэ.

2.2. Хоёр талын харилцан тохиролцсоноор дээрх обьектуудыг байнгын 1 пост, 4 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 24 цагийн турш хамгаалах ажлыг хамгаалагч тал зохион байгуулна.

2.3. Хоёр тал харилцан тохиролцсоноор нэг хамгаалалтын ажилтан ажиллуулсны нэг сарын үйлчилгээний хөлсийг /ажлын өдрүүдэд өдрийн нэг удаа хоолоор хангана /1,750,000 (нэг

сая долоон зуун тавин мянга) төгрөг байхаар тохиролцов. Уг дүн нь НӨАТ тооцогдсон дүн болно.

2.4. Хамгаалагч талын сар тутмын ажлын гүйцэтгэлийг энэхүү гэрээний Хавсралт №1 болох "Гүйцэттэлийн үзүүлэлтийн үнэлгээ"–ний хүснэгтээр дүгнэх ба тухайн хамгаалалтын албаны ажлын үр дүнг Үйлчлүүлэгч талын менежер баталгаажуулна.

2.5. Хамгаалагч тал объектуудын хамгаалалтыг өдөр тутам удирдан зохион байгуулах ба үйлчүүлэгч талтай хамгаалалтын талаар нягт хамтран ажиллана.

2.6. Хамгаалагч тал объектын онцлог, хууль дүрмээр тавигдах шаардлагад нийцүүлэн "Агуулахын хамгаалалтыг зохион байгуулах журам" болон "Харуул хамгаалалтын ажилтны хамгаалж буй объектод дагаж мөрдөх заавар"-ыг боловсруулан Үйлчлүүлэгч талын саналыг тусган баталж мөрдөн ажиллана.

2.7. Хамгаалагч тал нь объектын хамгаалалтанд ажиллах хамгаалалтын ажилтан нарыг Гэрээт харуул хамгаалалтын тухай Монгол улсын хуулийн хүрээнд сургалтанд хамруулж, үнэмлэхжүүлж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч объектын харуул хамгаалалтанд ажиллуулна.

2.8. Хамгаалалтанд ажиллах ажилтнуудын талаарх шаардлагатай мэдээллийг үйлчлүүлэгч талын хүсэлтээр Хамгаалагч тал тухай бүр гаргаж өгч байна.

2.9. Хоёр тал хамгаалж буй объектын хамгаалалтын бүс, биечлэн хамгаалах шаардлагатай хэсэг, харуулын харах секторын хүрээ, хяналтын бусад системийг ашиглах боломж зэргийг нарийвчлан судалсны үндсэн дээр хамгаалалтыг зохион байгууна.

2.10. Хамгаалалтын алба хаагчийн үүрэг гүйцэтгэх хугацаа өдөрт 24 цагаас хэтрэхгүй байх ба хүндэттэх шалтгаан гарсан тохиолдолд заавал үйлчлүүлэгч талд мэдэгдэж байна.

2.11. Байгалийн гамшиг, гэнэтийн халдлага, болзошгүй осол аваарийн үед объектын харуул хамгаалалтыг чангатгах, аюулгүй байдлыг хангах нэмэлт арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, үйлчлүүлэгч талын саналыг авч шаардлагатай үед мөрдөж ажиллана.

**Гурав. Гэрээний хугацаа, төлбөр**

3.1. Энэхүү гэрээг 2024 оны 12-р сарын 15-ны өдрөөс эхлэн 1 (нэг) жилийн хугацаатай байгуулав. Гэрээний хугацаа дуусахад үйлчлүүлэгч талын саналыг харгалзан 1 жилээр сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

3.2. Аль нэг талын санаачлагаар гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох бол нөгөө талдаа ажлын 14 хоногийн өмнө албан бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

3.3. Үйлчлүүлэгч байгууллага нь тухайн сард харуул хамгаалалт ажиллуулсан үйлчилгээний хөлс (НӨАТ-орсон) 7,000,000 (долоон сая) төгрөгийг дараа сарын 05 (тавны) дотор

Голомт банкны 3635102366 тоот дансанд ажлын шилжүүлнэ. Хамгаалагч тал НӨАТ-ын падааныг үйлчлүүлэгч талд тухай бүр өгнө.

**Дөрөв. Үйлчлүүлэгч талын эрх**

4.1. Харуул хамгаалалтын энэхүү гэрээний хэрэгжилт болон үүрэг гүйцэтгэлтэнд өдөр тутам хөндлөнгөөс хяналт тавих,

4.2. Харуулын албанд хамгаалалтын ажлыг сайжруулах шаардлага, тодорхой санал хүсэлтийг тавих, гүйцэтгэлийг хангахыг шаардах, хангуулах,

4.3. Тавьсан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх харуул хамгаалалтын албаны илтгэл, тайланг бичгээр хүлээж авах,

4.4. Харуул хамгаалалтанд ажиллах хамгаалалтын ажилтны талаарх шаардлагатай зарим мэдээлэлтэй танилцах, бие бялдар, харилцааны ёс зүйн хувьд шаардлага хангахгүй ажилтнаас татгалзаж солиулах,

4.5. Хамгаалагч талын ажилтнууд ээлж солилцох үед бэлэн байдлыг шалгах, албан шаардлага тавих, урьдчилан харилцан тохиролцсоны дагуу гүйцэтгэх нэмэлт ажлуудын талаар заавар өгөх,

4.6. Харуул хамгаалалтын үйл ажиллагааг сар тутам энэхүү гэрээний Хавсралт №1 болон Гүйцэтгэлийн гол үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэх,

4.7. Хамгаалалтын энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг, хуулиар тавигдсан шаардлагыг удаа дараа зөрчсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд хамгаалалтын гэрээг хугацаа дуусгалгүй цуцлах,

**Тав. Үйлчлүүлэгч талын үүрэг**

5.1. Хамгаалах объктыг шаардлагатай хяналтын камер, гэрэлтүүлгээр хангаж, хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг харуулын албанд гаргаж өгөх, Галын аюулгүй байдлын тухай Монгол улсын хуулийн дагуу шаардлагатай гал унтраах багаж хэрэгсэл, галын хор болон бусад хэрэгцээтэй зүйлээр хангах арга хэмжээ авах,

5.2. Харуул хамгаалалтын ажилтан, албаны ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлага хангасан харуулын байр, бүртгэлийн дэвтэр, дулаан, цахилгаанаар хангах,

5.3. Хамгаалж буй обеъктын хаалга гарц гэрэлтүүлэгдсэн байх нөхцлийг хангах,

5.4. Өөрийн байгууллагад гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг харуул хамгаалалтын албанд цаг алдалгүй ажлын нэг өдрийн дотор мэдэгдэж байх,

5.5. Байгууллагын холбогдох ажилтнуудын хаягийн бүртгэл, хамгаалалтад байгаа объектод байнга нэвтрэх эрх бүхий хүмүүсийн болон гаднаас нэвтрэх хүмүүсийн талаарх мэдээллийг цаг тухайд нь өгч байх,

5.6. Ажлын өдрүүдэд өдрийн 1 удаа нэг, хоёрдугаар хоолоор хангах,

5.7. Ажил дуусмагц агуулахыг цоожилж, лацдан харуулд хүлээлгэн өгөх,

5.8. Байгалийн гамшиг, гэнэтийн аюулаас компанийн өмч хөрөнгийг хамгаалахад идэвх зүтгэлтэй ажилласан хамгаалалтын албан хаагчдыг шагнаж урамшуулах,

5.9. Хамгаалалтын албан хаагчид аливаа халдлагын үед гэмтэл бэртэл авсан тохиолдолд эмнэлгийн яаралтай тусламж авахад нь дэмжлэг үзүүлэх,

5.10. Хамгаалагч талын ирүүлсэн сарын ажлын тайлантай танилцаж дүгнэх

5.11. Хамгаалагч талын ажилтнуудын ХАБЭА-н тухай хуулинд заагдсан зааварчилгаагаар хангах үүргийг хүлээхгүй ба Хамгаалагч талын буруутай үйлдэлтэй холбоотой, гадны халдлагатай холбооотойгоор харуул хамгаалалтын ажилтан үйлдвэрийн осол, хурц хордлогод өртөх аваас Үйлчлүүлэгч тал хариуцлага хүлээхгүй.

**Зургаа. Хамгаалагч талын эрх**

6.1. Хамгаалж байгаа эд хөрөнгө, объектын талаар шаардлагатай мэдээлэл авах,

6.2. Хамгаалалтыг сайжруулах асуудлаар үйлчлүүлэгч талд санал хүсэлт тавьж шийдвэрлүүлэх,

6.3. Хамгаалах эд хөрөнгө, объект гэрээнд заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол хүлээн авахаас татгалзах,

6.4. Хавсралт №1-т заагдсан гүйцэтгэлийн үнэлгээний нэмэх/хасах үзүүлэлтүүдийн дагуу тухайн сарын ажлаа үнэлүүлж хасалт болон урамшуулал тооцуулах,

6.5. Өөрийн үүрэгтэй холбоотой үйлчлүүлэгч байгууллагын дотоод журамтай танилцах,

6.6. Хамгаалалтын ажилтнуудын аюулгүй ажиллагааны мэдлэгийг нэмэгдүүлэх талаар Үйлчлүүлэгч талд хүсэлт гаргаж Үйлчлүүлэгч талаас сургалт авах,

**Долоо. Хамгаалагч талын үүрэг**

7.1. Энэхүү гэрээ болон "Харуул хамгаалалтыг зохион байгуулах журам"-ын дагуу обьектын хамгаалалтыг тасралтгүй чанд сонор байх зарчимд тулгуурлан удирдан зохион байгуулах,

7.2. Хамгаалалтын ажилтны ажил, амралтын цаг хуульд нийцсэн байх ба үүрэг гүйцэтгэх хугацааг сунгах, улируулан ажиллуулахгүй байх,

7.3. Хамгаалах эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал, лац ломбыг шалгаж хүлээн авах, хүлээлгэж өгөх, хэрэв эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал алдагдсан, лац ломбо хөдөлсөн байвал энэ тухай үйлчлүүлэгч болон Хамгаалалтын албанд нэн даруй мэдэгдэх,

7.4. Хариуцсан объектын эд хөрөнгө, машин техник бусад хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг нэг бүрчлэн шалгаж ээлж тутамд хүлээлцэн рапортын дэвтэрт тэмдэглэж байх,

7.5. Хамгаалтын бие бүрэлдэхүүнийг эрх зүйн чадамжтай, 20-55 насны, эрүүл мэнд, бие бялдрын хувьд шаардлага хангасан, хамгаалалтын ажил үүрэг гүйцэтгэх болон бие хамгаалах, тусгай хэрэгсэл эзэмших чадвартай, тусгай сургалтад хамрагдсан, галт зэвсэгтэй харьцах эрх бүхий, хариуцлага хүлээх чадвартай ажилтнуудаар бүрдүүлж ажиллана.

7.6. Хамгаалалтын ажилтнууд албан үүрэг гүйцэтгэх хугацаандаа соёлч боловсон байдлыг эрхэмлэж, дүрэмт хувцасаа цэвэр үзэмжтэй эдлэж, хамгаалах болон тусгай хэрэгслийг дүрэм, журмын дагуу хэрэглэж, ажилтнууд болон хэрэглэгчидтэй зөв боловсон харьцах,

7.7. Хамгаалалтын ажлыг сайжруулах түүнийг боловсронгуй болгох талаар үйлчлүүлэгчийн тавьсан санал хүсэлтийг тогтоосон хугацаанд нь ажил хэрэгчээр шийдвэрлэн албан ёсоор хариуг мэдэгдэх,

7.8. Хамгаалж буй объектод гэнэтийн халдлага гарсан тохиолдолд эрх хэмжээ үүргийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч энэ тухай холбогдох эрх бүхий байгууллага болон үйлчлүүлэгч талын удирдлагад нэн даруй мэдэгдэх,

7.9. Үйлчлүүлэгч талын эд хөрөнгийг зүй бусаар авч ашиглах, эвдэн сүйтгэх, хулгайлах зэрэг гэмт хэргээс хамгаалах,

7.10. Агуулахын бүсэд дур мэдэн нэвтрэх оролдлогыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх,

7.11. Объектын орчинд онцгой байдал (үер, гал түймэр, газар хөдлөх зэрэг г.м) тохиолдох үед боломжтой бүх арга хэмжээ авах, мэдээлэх, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үйлчлүүлэгч талд санал тавьж шийдвэрлүүлэх,

7.12. Агуулахын бүсэд нэвтрэх бүх хүмүүсийн бичиг баримтыг шалгах, бие болон ачаа тээшинд нь үзлэг хийх, согтуурах зүйл хэрэглэсэн эсэхийг нь шалгах, бараа материал, эд зүйлс оруулах гаргахад хяналт тавих, зөрчил илэрвэл баримтжуулан үйлчлүүлэгч талын удирдлагад мэдэгдэж, арга хэмжээ авах,

7.13. Илрүүлсэн хэрэг зөрчлийн талаар шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх,

7.14. Хамгаалалтын албаны ажилтан нэг бүрийн ажил үүргээ гүйцэтгэж байх үед нь шаардлагатай тусгай хэрэгслээр хангасан байх. Үүнд: гав, резинэн ба цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, галт зэвсэг, цацруулагчтай хантааз, дуулга, богино долгионы гар станц, гар чийдэн,

7.15. Хамгаалалтын албан хаагчдыг цэвэр, өнгө үзэмжтэй, нэг загварын хувцаслах ба улирал, цаг агаарын нөхцөлд тааруулан ноосон болон саравчтай малгай, зуны болон өвлийн дулаан хувцасаар хангана.

7.16. Сар тутам обьектын хамгаалалтын талаархи ажлын тайлан бичиж, салбарын даргад танилцуулан, ГГҮ-ийн хүснэгтээр дүгнүүлж байх,

7.17. "Байгууллагын нууцын тухай хууль"-ийг баримтлан, үйлчлүүлэгчийн нууцыг чанд хадгалах, үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад сувгаар мэдээлэл дамжуулахгүй байх,

7.18. Хамгаалалтын ажилтан Үйлчлүүлэгч талын холбогдох ажилтны зөвшөөрөлгүйгээр объект, агуулахад нэвтрэхийг хориглоно,

7.19. Үйлчлүүлэгч талаас олгосон харуулын байрны эд хогшлыг ариг гамтай эдэлж хэрэглэх бөгөөд бүрэн бүтэн байдлыг хариуцаж, өөрсдийн буруугаас эвдэж гэмтээсэн тохиолдолд хариуцлага хүлээх,

7.20. Объектод түр нэвтрэгсдээс түр хураан авсан эд зүйлийг бүрэн бүтэн байлгах, тэдгээрийг дур мэдэн хэрэглэсэн, хууль бусаар ашигласан, эвдэж гэмтээсэн, алдаж үрэгдүүлсэн бол бүрэн хариуцлага хүлээнэ.

7.21. Хамгаалалтын бүсэд байрлах гэрэлтүүлэг, камер зэрэг хяналтын системийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, албаны нохойн эрүүл мэнд, хоололт, арчилгааг бүрэн хариуцана.

7.22. Төрийн байгууллагаас ирэх хяналт, шалгалтын явцад Хамгаалагч талын/түүний ажилтны буруутай үйл ажиллагаатай холбоотой зөрчил тогтоогдож торгуулийн арга хэмжээ авагдах аваас гарах зардлыг бүрэн хариуцах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх бүхий л арга хэмжээг өөрийн нөөц бололцоогоор түргэн, шуурхай шийдвэрлэх,

7.23. Хамгаалалтын ажилтан нь үүрэг гүйцэтгэх хугацаандаа согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис, нойрсуулах үйлчилгээтэй эм хэрэглэхийг бүрэн хориглоно,

7.24. Хамгаалалтын ажилтнуудыг Гэрээт харуул хамгаалалтын болон ХАБЭА-н тухай хуулийн хүрээнд зааварчилгаагаар хангах, сургалтад хамруулах ажлыг Хамгаалагч тал бүрэн хариуцаж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гаргахгүй байх нөхцлийг хангаж ажиллана,

7.25. Хамгаалалтын ажилтан нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд Хамгаалагч тал бүрэн хариуцлага хүлээнэ. Зөвхөн Үйлчлүүлэгч талын ажилтны буруутай үйлдлээс үүдсэн осолд мэргэжлийн байгууллагаар буруутай этгээд нь Үйлчлүүлэгч тал хэмээн тогтоогдсон тохиолдолд Үйлчлүүлэгч тал хариуцлага хүлээнэ.

**Найм. Хариуцлага, маргаан шийдвэрлэх**

8.1. Гэрээт хугацааны эхэнд 2 тал объектын эд хөрөнгийг жагсаалтын дагуу бүртгэн хүлээлцэж, гарын үсэг зурж баталгаажуулна.

